

“ТӨРИЙН БАНК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ

2026.04.30

АГУУЛГА

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	2
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол	3
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн	5
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр	6
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал:	7

Танилцуулах асуудал

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;	9
2. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулга;	27
3. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга.	27

Хэлэлцэх асуудал

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;	32
2. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;	33
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.	37
6. Саналын хуудасны загвар	38

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 27 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

- **Компанийн оноосон нэр:** “ТӨРИЙН БАНК” ХК
- **Хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
- **Хурал болох газар:** Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центр, “А” танхим
- **Хурал болох өдөр, цаг:** 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 09:00 цаг /Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигч хурал эхлэхээс 1 цагийн өмнө ирж бүртгэл хийлгэнэ/
- **Хурал болох хэлбэр:** Хосолсон /танхим болон зайнаас/
- **Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Танилцуулах асуудал:

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулга;
3. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга.

Хэлэлцэх асуудал:

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;
2. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
2. “Төрийн банк” ХК-ийн санхүүгийн жилийн тайлан;
3. “Төрийн банк” ХК-ийн санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
4. “Төрийн банк”-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
5. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад мэдээлэл.

Хувьцаа эзэмшигч Та 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл www.statebank.mn/ цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани;
- “Төрийн банк” ХК-ийн төв байр Монгол улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1;

Хуралд танхимаар оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр өгөх, эсвэл цахим хэлбэрээр Төрийн банкны цахим хуудас www.statebank.mn/-аар дамжуулан өгөх ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 17 цаг байна.

Хурал зохион байгуулах комисс

Утас: 75071881

Цахим шуудан: SBM_Shareholder@statebank.mn



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2026.03.20

№ 27

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 09 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центр, "А" танхимд хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг "Төрийн банк" ХК, "Монголын Хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын нийтэд хүргэх зарын загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах Комиссыг 5 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын Комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай цахим шийдлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 17 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах "Төрийн банк" ХК-ийн төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэр /www.statebank.mn/-ээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Зохион байгуулах комисс (Д.Сугар)-т даалгасугай.

15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисс (А.Батмөнх)-т даалгасугай.

16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Сангийн дэд сайд (Б.Хулан)-ыг томилсугай.

17. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЗОЛБОО

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
27 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Дотоод хяналт, шалгалтын газрын захирал А.Батмөнх

Комиссын гишүүд:

Харилцагчийн үйлчилгээний чанар, бүтээмжийн удирдлагын газрын
захирал О.Баасансүрэн

Хөгжүүлэлтийн хэлтсийн захирал Б.Цэндсүрэн

Дотоод хяналт, шалгалтын газрын ахлах хянан шалгагч А.Бямбазориг

Комиссын нарийн бичгийн дарга:

Харилцагчийн үйлчилгээний чанар, бүтээмжийн удирдлагын газрын
ахлах мэргэжилтэн А.Дулмаа

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах
08:00-09:00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Зохион байгуулах комисс
09:00-09:05	Хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс
09:05-09:10	Хурлын үйл ажиллагааг нээх	Хурлын дарга
09:10-09:15	Хурлын хөтөлбөр /танилцуулах, хэлэлцүүлэх асуудал/-ийг танилцуулах	Хурлын дарга
09:15-09:25	“Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга хийх	Гүйцэтгэх захирал
09:25-09:30	“Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулга хийх	ТУЗ-ийн дарга
09:30-09:35	“Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга хийх	ТУЗ-ийн дарга
09:35-09:40	Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй тайлбарлах	Тооллогын комисс
09:40-09:45	“Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэх	Хурлын дарга
09:45-10:05	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
10:05-10:10	“Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэх	Хурлын дарга
10:10-10:30	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
10:30-10:35	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай тогтоолын төслийг хэлэлцэх	Нэр дэвшүүлэх хорооны дарга Б.Цэвэгжав
10:35-10:55	Асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
10:55-11:05	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалт	Тооллогын комисс
11:05-11:30	Завсарлага /санал тоолох/	Тооллогын комисс
11:30-11:35	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах	Тооллогын комисс
11:35-11:40	Хурлын шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах	Хурлын дарга

"Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



"ТӨРИЙН БАНК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

ТАНИЛЦАХ АСУУДАЛ:

1. "Төрийн банк" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. "Төрийн банк" ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай танилцуулга;
3. "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. "Төрийн банк" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;
2. "Төрийн банк" ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
3. "Төрийн банк" ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

--oOo--

ТАНИЛЦУУЛАХ АСУУДАЛ

- ① ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

БАНКНЫ ТУХАЙ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



БНСУ дахь
төлөөлөгчийн
газар



Нийт
салбар **490**



Нийт ажилтан

3,160

Төв

664

Улаанбаатарын
нэгж

682


Орон нутгийн
нэгж

1,814


ОЛОЛТ, АМЖИЛТ



Зээлжих зэрэглэлийг “B1” хэтийн төлөвийг “Тогтвортой” болгон ахиуллаа.



Cargill байгууллагаас 45.0 сая ам.долларын эх үүсвэрийг татлаа.



Банк гадаад зах зээлд анх удаа 200.0 сая ам.долларын бонд гаргалаа.



Төрийн банк “ТӨП-100 ААН” жагсаалтад зургаадугаарт эрэмбэлэгдлээ



Цахим нэгж зах зээлд шинээр нэвтрүүлээ.



Тогтвортой байдлын зөвлөх багаас “Уур амьсгалын эрсдэлийн зөвлөх үйлчилгээ”-г авлаа.



Монголын Ногоон барилгын хүрээлэнгээс “Ногоон барилгын манлайлагч байгууллага 2025” шагналыг хүртлээ.



Төрбум мод сангаас “2025 оны төсөл, хөтөлбөр санхүүжүүлэгч, шилдэг дэмжигч банк”-аар шалгарлаа.



- ▶ ISO:45001
- ▶ ISO:31000:2020
- ▶ ISO:27001:2022
- ▶ ISO:PSI-dss 4.0.1
- ▶ ISO:20022

Стандартуудыг тус тус нэвтрүүлээ.


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Төрийн банк нь Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилласан бөгөөд банкны системийн үзүүлэлттэй харьцуулахад дунджаас дээгүүр үзүүлэлттэйгээр жил бүр тогтмол өсөлтийг гарган ажиллаж байна.



НИЙТ АКТИВ


/их наяд төгрөг/



Сүүлийн гурван жилийн дундаж өсөлт 17.6 хувь

ЗЭЭЛИЙН БАГЦ


/их наяд төгрөг/



Давхардсан тоогоор 1.8 сая харилцагчид 4.1 их наяд төгрөгийн зээл олгов.

ЦЭВЭР АШИГ


/тэрбум төгрөг/



Цэвэр ашгийн хэмжээ 96.4 тэрбум төгрөгт хүрэв.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

/их наяд төгрөг/



Сүүлийн гурван жилийн дундаж өсөлт 18.4 хувь

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	16.11%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	16.11%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	32.53%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< + - 15%	-0.31%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< + - 30%	-0.33%

Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилласнаас гадна, тайлант жилийн эцэст активын өгөөж 1.57%, өөрийн хөрөнгийн өгөөж 16.05%-д хүрлээ.

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон нийт цалингийн дүн:

2025 он	Дүн /сая төгрөгөөр/
Цалин	163.7
Нийгмийн даатгалын шимтгэл	20.5
Нийт дүн	184.2

Гүйцэтгэх удирдлага болон Эрх бүхий албан тушаалтнуудад олгосон нийт цалин, урамшууллын дүн:

2025 он	Дүн /сая төгрөгөөр/
Цалин	4,249.4
Урамшуулал	577.6
Нийгмийн даатгалын шимтгэл	603.4
Нийт дүн	5,430.4

ЭРСДЭЛИЙН САНГААС ХОРОГДУУЛСАН АКТИВ:

№	Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”	Төлбөр хариуцагч	Активын дүн /сая төгрөгөөр/
1	3.5.1.2. Төлбөр хариуцагчаас тодорхой хэсгийг гаргуулахаар шүүхийн шийдвэр гарсан боловч үлдэх хэсгийг төлбөр хариуцагч хариуцахгүй болсныг тогтоосон шүүхийн шийдвэрээр тухайн үлдэх хэсгийг;	8	21.41
2	3.5.1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай шүүгчийн шийдвэр болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор холбогдох активын дүн;	5	424.51
3	3.5.1.4. Банкны үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж тооцогдсон муу ангилалтай активыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр;	46	126.87
Нийт		59	572.79

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙГДСЭН ХЭЛЦЭЛД ӨГСӨН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

ТӨРИЙН БАНК ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

36. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гол удирдах албан тушаалтнууд Банкны бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд энгийн нөхцөлтэйгөөр (бусад харилцагчид болон ажилтнууд ижил үйлчилгээ авахад санал болгодогтой ижил хүү болон барьцааны нөхцөл) банкнаас үйлчилгээгээ авдаг. Эдгээр ажил гүйлгээнүүдэд энгийн ажил гүйлгээнээс ялгарах онцлог эрсдэл байхгүй байна.

Эх сурвалж: “Эрнст энд Янг Монголия аудит” ХХК -ийн хөндлөнгийн аудитын тайлан

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Стратегийн тэргүүлэх таван чиглэлийн хүрээнд 18 үндсэн зорилт, 130 дэд зорилт дэвшүүлэн 94.7 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.



ОНЦЛОХ АЖИЛ



Төрийн банк анх удаа Олон улсын зах зээлд 200 сая ам.долларын дүнтэй, 8.9 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай бондыг амжилттай гаргалаа. Бондын 200 сая ам.долларын эх үүсвэрээс 50 сая ам.долларын эх үүсвэрийг тогтвортой, ногоон хөгжлийг дэмжихэд чиглэсэн байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулна.



И-Билл үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж И-Монголиа аппликейшнтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү үйлчилгээг ашиглан харилцагч И-билл үйлчилгээ нэвтэрсэн бүх төрлийн аппликейшнээр хэрэглээний төлбөрөө төлөх боломжтой боллоо.



Татварын ерөнхий газар, Санхүү мэдээллийн технологийн төв болон “Төрийн банк” ХК нь хамтран картаар хийсэн гүйлгээний баримтыг шууд харилцагчийн Ebarimt-ын системд автоматаар бүртгүүлэх хөгжүүлэлтийг хийж нэвтрүүллээ.



Банкны баталгааны маягтууд дахин давтагдашгүй QR дугаар бүхий нууцлалтай боллоо.



Дансны тусгай дугаар үйлчилгээ, Эрүүл иргэн багц бүтээгдэхүүнийг Гялсбанк үйлчилгээг ашиглан авах боломжийг бүрдүүллээ.



“Эрүүл иргэн” багц бүтээгдэхүүнийг ашигладаг харилцагчдадаа эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл амьдралын жигүүр” ТББ-тай хамтран 16 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагатай уулзалт зохион байгуулж, тэдгээр байгууллагуудын ажилтнуудад бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл, сургалтыг зохион байгуулсан. Эдгээр ажлын үр дүнд дараах 7 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Үүнд:



Төрийн банк “Тэрбум мод” сантай “Хамтран ажиллах гэрээ”-г байгууллаа.



Төрийн бодлогын зохицуулалт, банкны салбарын санхүүжилтийн нөөц болон хувийн хэвшлийн инновацыг мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэгтгэх замаар Тогтвортой хөгжил зорилт, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой “Тогтвортой өсөлт-хамтын түншлэл” цогц нэтворкинг арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж байна.

Онцлох шинэ
бүтээгдэхүүн
үйлчилгээ



Ногоон бэлтгэн нийлүүлэгчийн зээл



Малчны цахим зээл



Олон улсын Платинум кредит карт



“Санхүүгийн түрээс”



Green KUB - Грийн КУБ



Ногоон орон сууцны зээл



Ногоон харилцах данс



Gyalsdaatgal аппликейшн



“Эхлэл”Хүүхдийн хадгаламж



Ногоон бизнесийн зээл

ЦАХИМ ШИЛЖИЛТ



Гялсбанк 3.0

30 хөгжүүлэлт, нэмэлт сайжруулалт, онцлох сайжруулалт



Хувийн санхүү модулийн сайжруулалт хийж, нэхэмжлэх үүсгэх, төлөх боломжтой боллоо.

Шүүхийн шийдвэрийн ерөнхий газрын нэхэмжлэл төлөх боломжтой болсон.

Банк хооронд болон банк доторх гүйлгээг IBAN дансаар хийдэг болсон.

Хүүхдийн мөнгөний харилцах данс болон урьдчилсан хүүт хугацаагүй хадгаламж, Эхлэл хүүхдийн хадгаламж, сургалтын хадгаламжийг нээдэг болсон.

Байгууллагын харилцагч тоон гарын үсэг ашиглан нэвтрэх болон гүйлгээ хийх боломжтой болсон.

Киоск 2.0 шинэ хувилбарын сайжруулалт **15**



Дансны тодорхойлолт авах, Захиалгат шилжүүлэг үүсгэх, лавлах, засах, цуцлах, Иргэд мессеж мэдээ, хувийн дугаарын үйлчилгээнд бүртгүүлэх, Автомат хуримтлалын үйлчилгээнд бүртгүүлэх боломжийг нэвтрүүлсэн.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран нэвтрүүлж, "төлбөргүй" 69 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг авах боломжтой болсон.

Нэвтэрсэн төрлөөс хамаарч баталгаажуулалтын төрөлд өөрчлөлт оров.

УБЕГ-тай хамтран Тоон гарын үсэг шинээр олгох хөгжүүлэлт хийн нэвтрүүлэв.



НЭС үндсэн системийн нэмэлт сайжруулалт



ERP систем программ **6** хөгжүүлэлт



Дэд программын нэмэлт сайжруулалтын **9** ажил

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН
БОНД

200.0

сая ам.долларын
эх үүсвэр татлаа

Ногоон зээл

116.9

тэрбум төгрөг

▲ 118.2%

63,3 тэрбум төгрөг

2.288

харилцагч

▲ 104.8%

1,171 харилцагч

2.80%

Нийт зээлд
зэлэх хувь

▲ 1.27%

нэгж хувь

Тогтвортой
хөгжилд
чиглэсэн зээл

384.6

тэрбум төгрөг

▲ 116.0%

206,5 тэрбум төгрөг

8.814

харилцагч

▲ 99.8%

4,402 харилцагч

9.21%

Нийт зээлд
зэлэх хувь

▲ 4.12%

нэгж хувь

■ ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ"Ди би эм ассет
менежмент" ХХКЭЗЭЛИЙН БАТААН
ДААЛТЫН САНМонголын ногоон
санхүүгийн корпорацТогтвортой
санхүүжилтийн холбооМонголын амины орон сууцны
инноваци хөгжлийн төвМонголын бэлчээр судлалын
ногоон алт төвМонголын Ногоон Барилгын
Хүрээлэн НҮТББMONGOLIAN
GREEN BUILDING
COUNCILМонголын
Байгалийн
Өв Сан

WE SUPPORT

НҮБ-ын Даян
дэлхийн гэрээНүүрстөрөгчийн
НББ-ийн санхүүгийн
түншлэлWe Finance
CodeБанкны Тогтвортой
санхүүжилтийн
хүрээХөндлөнгийн
үнэлгээУур амьсгалын
эрсдэлийн зөвлөх
үйлчилгээ

■ ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ, ТАЙЛАГНАЛ

Банкны 2025 оны Тогтвортой хөгжлийн тайланд байгаль орчин, нийгэм, засаглалын үзүүлэлтүүд, тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг олон нийтэд танилцууллаа.



Банкны Байгаль орчин, нийгэм засаглалын тайланг Монголын хөрөнгийн биржид 3 дахь жилдээ тайлагналаа.



Банкны "Тогтвортой хөгжлийн зорилтууд"-ыг батлууллаа.



Банкны "Хүлэмжийн хийн ялгаруулалтын менежментийн төлөвлөгөө"-г боловсрууллаа.



Нэгдсэн Үндэсний Байгууллагын Даян Дэлхийн гэрээний хүрээнд явцын тайлан хүргүүллээ.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Төрийн банк байгаль орчин, нийгмийн хариуцлагын чиглэлээр манлайлж **“Тэрбум мод”** сангийн **“Шилдэг дэмжигч банк”**-аар мөн Монголын Ногоон барилгын хүрээлэнгийн **“Financial Solution”** чиглэлийн манлайлагч байгууллагаар тус тус шалгарсан нь бидний тогтвортой хөгжлийн талаарх зорилго, амлалтыг бататгасан чухал үнэлгээ боллоо.



Банкны ажилтнуудын санаачилгаар “Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ” аяныг орон даяар өрнүүлэн:

- **8000** гаруй га талбайгаас
- **1000** орчим тонн хог хаягдал цэвэрлэлээ



Модыг мод(а) болгоё аяныг дөрөв дэх жилдээ орон даяар амжилттай зохион байгууллаа.

2025 оны 5 болон 10-р сард



34 нэр төрлийн

• **4,772** ширхэг мод тарьлаа




Бизнес инкубатор төвөөр дамжуулан Санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.



Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Төрийн банкнаас өндөр насны тэтгэвэртээ гарсан ахмад ажилтнуудаа хүлээн авч, тэдний үнэтэй хөдөлмөр, байгуулсан гавьяаг нь дурсан хүндэтгэл үзүүлэв.



Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран харилцагчдадаа цаг агаарын болзошгүй аюул, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гялсбанк аппликейшн”-аар дамжуулан 42 удаа сэрэмжлүүлэх “МЭДЭГДЭЛ” мэдээллийг хүргүүлээ.



“ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ”-ийн чиглэлээр олон нийтэд мэдээлэл өгөх, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5 цуврал контент бэлтгэн банкны албан ёсны сошиал сувгуудаар дамжуулан харилцагч олон нийтэд хүргэсэн.



Төрийн банк нь тогтвортой хөгжил, ногоон өсөлтийг түүчээлэгч системд нөлөө бүхий банкны хувьд, дотоод болон гадаад орчинд чиглэсэн авлигын эсрэг арга хэмжээг үйл ажиллагаандаа шат дараатай тусган хэрэгжүүлж Авлигатай тэмцэх газартай хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй хэн бүхэнд “ҮГҮЙ” гэж хэлье, Төрийн банк “Авлигын эсрэг нэгдье” аянд нэгдэн ажилтнууд болон харилцагч олон нийтэд мэдээлэл, уриалга гарган ажилласан.



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН



Ernst & Young Mongolia Audit LLC
15/F, Altan Joloo Tower
Seoul Street 13/A
Ulaanbaatar 14252
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Зөрчилгүй дүгнэлт

Бид Төрийн Банк ХК (“Банк”)–ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталж гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөмөөс баталсан “Мэргэисэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Банкаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудал нэг бүрийг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Зээлийн үнэ цэнийн бууралт	
Удирдлага нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцходоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашиглан тооцоолдог. Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны нийт хөрөнгийн 60 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын гол асуудал гэж үзсэн.	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын санг тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид Банкны Зээлийн Үнэ Цэнийн Хүлээгдэж буй Алдагдал (“ЗҮЦХА”)–ыг батлах, бүртгэх, хянах хяналтын загвар болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх, мөн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцоолох ЗҮЦХА–ын загварт банкны ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Арга зүйг үнэлэхдээ бид банкны ЗҮЦХА–ын загвар болон ашигласан арга зүй, таамаглалын удирдлагын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлтэй байдлыг үнэлж, салбарын жишигтэй харьцуулсан.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Зээлийн үнэ цэнийн бууралт Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Зээлийн Үнэ Цэнийн Хүлээгдэж буй Алдагдал ("ЗҮЦХА")-ын загварт суурилсан. Энэхүү ЗҮЦХА-ын загварын бүрэлдэхүүн хэсгүүд нь ихээхэн төсөөлөл, болон тооцоолол шаарддаг. Үүнд: - Санхүүгийн хөрөнгийн шатлал; - ЗҮЦХА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Чанаргүйдлийн Магадлал ("ЧМ") болон Алдагдалд Хүргэх Чанаргүйдэл ("АХЧ")-ийг сонгох; - Чанаргүйдэлд Өртөх Дүн ("ЧӨД") болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хөрвүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; - ЗҮЦХА-ын загварт оруулах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх; болон - Ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоход хэрэглэсэн олон төрлийн төсөөлөл болон хүчин зүйлс дээр суурилан тусгайлан үнэлсэн зээлүүдийн үнэ цэнийн бууралтын санг тооцоолох. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд болон үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2.5 болон 3-д тус тус толилуулсан. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаатай хамааралтай бусад толилуулга болон зээлийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн тайлангийн Тодруулга 10, 16 болон 34.2-д тус тус толилуулсан.	Түүнчлэн бид ашигласан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шатлалын ангиллын үндэслэл, ЧМ, АХЧ болон ЧӨД -ийг тодорхойлох оновчтой байдал, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн. Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, харилцагчдад оноосон зээлжих зэрэглэлийг анхны хүлээн зөвшөөрсөн өдрөөр болон санхүүгийн тайлангийн өдрөөр тус тус шалгасан. Бид мөн насжилтын тайлангийн дүнг санхүүгийн бүртгэлд тусгасан дүнтэй тулгах замаар насжилтын тайлангийн иж бүрэн байдлыг шалгаж, санамсаргүй түүврийн аргаар насжилтын тайлангийн мэдээллүүдийг холбогдох баримтуудтай тулгах замаар насжилтын тайлангийн үнэн зөв байдлыг шалгасан. Бид ЗҮЦХА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Банкны боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд: - Түүхэн ЧМ, АХЧ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдийн зөв зохистой байдлыг санамсаргүй түүврийн аргаар шалгасан; - Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; - ЧӨД болон зээлийн хөрвүүлэлтийн коэффициентүүдийн хүлээлтийн үнэн зөв байдлыг шалгасан; - Үнэ цэнийн бууралтыг үнэлэх тусгайлан үнэлсэн зээлүүдээс сонгогдсон түүвэрүүдийн хувьд бид ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгал болон барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх Банкны таамаглалуудыг хянаж үзсэн. Бид ЗҮЦХА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжийг тууштай ашигласан байдлыг авч үзсэн. Мөн бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл (“Бусад хэсэг”) багтана.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Жилийн тайлангийн “Бусад хэсэг”-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглах эрх бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцоолууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгддэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглах эрх бүхий этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртээх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын гэрээт ажлын партнер нь Адриан Чу болно.

Бусад зүйл


Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу. Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан:


БУЛАНБАЙН ХАБЫЛХАЙРАТ
Захирал

Баталсан:


АДРИАН ЧУ
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 13

ТӨРИЙН БАНК ХК
**2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2025 мян.төг	2024 мян.төг
Үр ашигт хүүгээр тооцсон хүүний орлого	5	802,915,744	651,613,814
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	5	22,872,922	22,731,188
Үр ашигт хүүгээр тооцсон хүү болон түүнтэй адилтгах зардал	6	(537,999,572)	(372,203,001)
Хүүгийн цэвэр орлого		287,789,094	302,142,001
Хураамж ба шимтгэлийн орлого	7	55,980,755	48,267,729
Хураамж ба шимтгэлийн зардал	7	(19,017,393)	(16,317,569)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого		36,963,362	31,950,160
Арилжааны цэвэр орлого	8	8,253,231	5,524,096
Үйл ажиллагааны бусад орлого/(зардал)	9	6,534,705	2,729,106
Нийт үйл ажиллагааны орлого		339,540,392	342,345,363
Санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	10	7,735,795	15,045,866
Үйл ажиллагааны цэвэр орлого		347,276,187	357,391,229
Үйл ажиллагааны зардал	11	(223,330,274)	(217,671,325)
Татварын өмнөх ашиг		123,945,913	139,719,904
Орлогын албан татварын зардал	12	(27,536,094)	(31,753,945)
Тайлант жилийн ашиг		96,409,819	107,965,959
Нэгж хувьцааны ашиг			
Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах тухайн жилийн суурь ашиг	31	127.68	142.98
Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах тухайн жилийн хорогдуулсан ашиг	31	127.68	142.98
Бусад дэлгэрэнгүй орлого:			
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого:</i>			
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд			
бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	31	(57,244)	1,149,488
Дээрхитэй холбоотой орлогын албан татвар	31	14,311	(288,339)
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:</i>			
Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний гарз	31	—	(61,524)
Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт	31	(5,920)	(61,899)
Дээрхитэй холбоотой орлогын албан татвар		—	—
Бусад дэлгэрэнгүй орлого		(48,853)	737,726
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		96,360,966	108,703,685

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

ТӨРИЙН БАНК ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2025 мян.төг	2024 мян.төг
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах, хадгаламж	13	737,508,808	597,680,173
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	178,238,135	224,702,816
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	15	22,868,202	5,638,743
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	4,050,350,416	3,396,732,092
Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зориулалттай	17	8,590,736	8,078,520
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	17	216,984,610	153,247,705
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр	18	1,171,338,077	1,564,045,931
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр	18	137,011	132,029
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр	18	90,719,077	49,911,937
Бусад хөрөнгө	19	50,318,140	37,824,135
Борлуулах зориулалттай хөрөнгө	20	3,060,121	668,364
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	21	2,189,557	2,170,476
Үндсэн хөрөнгө	22	183,643,563	171,678,919
Бист бус хөрөнгө	23	5,484,017	5,967,543
Ашиглах эрхтэй хөрөнгө	24	383,655	5,331,068
Нийт хөрөнгө		6,721,814,125	6,223,810,451
Өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25	320,277,879	419,755,053
Репо хэлцэл	26	106,875,647	106,875,647
Харилцагчдын харилцах, хадгаламж	27	4,170,447,111	4,285,278,690
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	15	24,403,010	9,176,467
Дотоодод гаргасан үнэт цаас	28	–	10,044,464
Гадаадад гаргасан үнэт цаас	28	723,013,897	–
Зээлээр авсан санхүүжилт	29	646,762,313	679,433,885
Бусад өр төлбөр	30	35,692,875	59,975,772
Түрээсийн өглөг	24	420,234	6,135,919
Орлогын албан татварын өглөг	12	3,053,657	9,467,078
Хойшлогдсон татварын өр төлбөр	12	8,539,941	3,601,251
Нийт өр төлбөр		6,039,486,564	5,589,744,226
Эздийн өмч			
Энгийн хувьцаа	31	188,774,063	188,774,063
Нэмж төлөгдсөн капитал	31	14,652,725	14,652,725
Бусад нөөц	31	70,569,909	70,618,762
Хуримтлагдсан ашиг		408,330,864	360,020,675
Нийт эздийн өмч		682,327,561	634,066,225
Нийт өр төлбөр ба эздийн өмч		6,721,814,125	6,223,810,451

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

ТАНИЛЦУУЛАХ АСУУДАЛ

- ② “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС
НОГДОЛ АШИГ ХУВААРИЛСАН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА
- ③ “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭД 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР
ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛСАН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу банкны 2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан болно.

№	Агуулга	Утга
1	Ногдол ашгийг олгож эхэлсэн огноо	2025.04.25
2	Энгийн хувьцаа	755,096,250 /ширхэг/
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	10,331
4	Нэгж хувьцаанд оногдуулан хуваарилсан ногдол ашгийн хэмжээ	63.70 /төгрөг/
5	Ногдол ашиг олгосон дүн	48,099,631,125 /төгрөг/

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу банкны 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 51.80 /тавин нэгэн төгрөг наян мөнгө/ төгрөг буюу нийт 39.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон “Төрийн банк” ХК-ийн Ногдол ашгийн бодлогод заасан зохих шаардлагуудыг хангахаар байна.

№	Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Ногдол ашиг хуваарилсны дараа шаардлага хангах эсэх
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	Тийм
2	Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	Тийм
3	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	Тийм
4	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< + - 15%	Тийм
5	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< + - 30%	Тийм

/2025.12.31-ний өдрийн санхүүгийн тайланд үндэслэн тооцов./



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2026.02.13

№ 19

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35.3 дугаар хэсэг, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.7 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, "Төрийн банк" ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.

2. "Төрийн банк" ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангаарх татварын дараах цэвэр ашгаас нийт эргэлтэд байгаа 755,096,250 (долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхэг хувьцаанд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

3. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 51.80 (тавин нэгэн төгрөг наян мөнгө) төгрөг байхаар тогтоосугай.

4. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

5. Ногдол ашгийг эрх бүхий зохицуулагч байгууллагын зөвшөөрлийг хүлээн авсны үндсэн дээр 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан олгохыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

6. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

7. Тогтоолын хувийг Монголбанканд хүргүүлж ногдол ашиг хуваарилах зөвшөөрөл авах, Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

8. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч (Г.Золбоо)-д үүрэг болгосугай.

9. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЗОЛБОО

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2026.03.20

№ 26

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10.13.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайланг танилцуулах, “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч (Г.Золбоо)-д тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЗОЛБОО



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2026.03.13

№ 24

Улаанбаатар хот

**“Төрийн банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн
тайланд дүгнэлт өгөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10.13.15 дахь заалт, “Эрнст энд Янг Монголия аудит” ХХК-ийн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг зөрчилгүй, материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн гэж дүгнэснийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Хөндлөнгийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д үүрэг болгосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд банкны аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулж, хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч (Г.Золбоо)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЗОЛБОО

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

2. “Төрийн банк” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Б.ХУЛАН

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ ②**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ****“Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 502 дугаар тогтоол, “Төрийн банк” ХК-ийн 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмсүгэй:

1/ 15 дугаар зүйлийн 15.14.34 дэх заалт:

“15.14.34. Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомж, банкны дүрэм, ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд банкны эд хөрөнгөтэй холбоотой эрх эдэлж, үүрэг хүлээх, гэрээ, хэлцэл байгуулах;”

2. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 10 дугаар зүйлийн 10.13.9 дэх заалт:

“10.13.9. Эрх бүхий байгууллагаас санал авсны үндсэн дээр банкны эд хөрөнгөтэй холбоотой дараах шийдвэрийг хууль тогтоомжид заасны дагуу гаргах:

10.13.9.а. Эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;

10.13.9.б. Эд хөрөнгийг актлах, данснаас хасах эсэх;

10.13.9.в. Үндсэн хөрөнгийг худалдах;

10.13.9.г. Үл хөдлөх хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэх;

10.13.9.д. Хөрөнгийн дахин үнэлгээний бүртгэл хийх;

10.13.9.е. Их засварын зардлаар өртөг нэмэгдүүлэн бүртгэх;

10.13.9.ё. Түрээсийн төлбөрийн жишиг үнийг батлах.”

2/ 10 дугаар зүйлийн 10.13.26 дахь заалт:

“10.13.26. Банкны байгаль орчин, нийгэм, засаглал, үйл ажиллагаа, эд хөрөнгийн талаарх бодлого, журмыг батлах;”

3. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 15 дугаар зүйлийн 15.14.1 дэх заалтын “дотоод заавар, дүрэм, журмыг” гэснийг “бодлогын баримт бичгийг” гэж өөрчилсүгэй.

4. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 15 дугаар зүйлийн 15.14.34 дэх заалтын дугаарыг “15.14.35” гэж өөрчилсүгэй.

5. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

6. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д үүрэг болгосугай.

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



Ц.БУЛГАНХИШИГ

Боловсрол, мэргэжил:

- 1983-1988 онд МУИС-Хууль зүйн сургууль, Эрх зүйч, Бакалавр
- 1998 онд МУИС- Хууль зүйн сургууль, Хууль зүйн ухааны магистр
- 1998-1999 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, Бизнесийн удирдлагын арга зүйч, зохион байгуулагч
- 2002-2004 онд ОХУ-ын Хууль зүйн академи, Эрх зүйч, Аспирант

Ажлын туршлага:

- 1988-1991 онд Дархан хотын Хууль зүйн зөвлөгөө өгөх газар, Хуулийн зөвлөх
- 1991-2003 онд Дархан хотын шүүх, Шүүгч
- 2004-2009 онд Монголын өмгөөлөгчдийн холбоо, Өмгөөлөгч, хуульч
- 2009-2014 онд Төрийн банк ХК, Ахлах хуульч,
- 2014-2017 онд Монгол банк, Хуулийн мэргэжилтэн
- 2017-2023 Монгол Улсын Хөгжлийн банк, Ахлах хуульч
- 2023 оноос Монголын Олон улсын арбитр, Арбитрч



Т.АРИУНБААТАР

Боловсрол, мэргэжил:

- 1992-1996 онд Төмөр замын коллеж, Вагон техник механик
- 2002-2006 онд Хилийн цэргийн дээд сургууль, Эрх зүйч, Бакалавр
- 2013-2015 онд Этүгэн их сургууль, Төрийн захиргааны удирдлага, Магистр
- 2015-2017 онд ОХУ-Эрхүү хотын Зам харилцааны их сургууль, Төмөр замын тээврийн удирдлага зохион байгуулалт, Магистр

Ажлын туршлага:

- 1998-2004 онд УБТЗ суудлын вагон депо, Вагон засварчин, мастер
- 2004-2006 онд Тайм констракшн ХХК, Төслийн менежер
- 2006-2009 онд Тайм констракшн ХХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал
- 2009-2014 онд БТЕГ ХХК, Вагон хүлээн авагч
- 2015 онд ЗТЯ-ны харьяа, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ, Хэлтсийн дарга
- 2015-2019 онд ЗТЯ-ны харьяа, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ, Захирал
- 2021-2024 онд КФС Трансвосток Монголия ХХК, Гүйцэтгэх захирал
- 2024-2025 Амгалан дулааны станц ТӨХК, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
- 2025 оноос УБЦТС ТӨХК-ийн Баянзүрх хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга



Г.САРУУЛ

Боловсрол, мэргэжил:

- 1997-2001 онд Улаанбаатар-эрдэм их сургууль, Эрх зүйч, Бакалавр
- 2001-2002 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, Удирдлагын арга зүйч, зохион байгуулагч

Ажлын туршлага:

- 2012-2015 онд Гадаад хэргийн яам, Дипломат байгууллага, Худалдааны менежер
- 2015 оноос Амгалан дулааны станц ТӨХК, Хуулийн мэргэжилтэн

**С.БОЛДБАЯР****Боловсрол, мэргэжил:**

- 2002-2006 онд Цагдаагийн академи, Эрх зүйч, Бакалавр
- 2017-2018 онд Билэг дээд сургууль, Хууль зүйн ухааны магистр

Ажлын туршлага:

- 2006-2018 онд Цагдаагийн ерөнхий газар, Ахлах мэргэжилтэн
- 2018-2023 онд Хөвсгөл аймгийн цагдаагийн газар, Дэд дарга
- 2023-2024 онд Цагдаагийн ерөнхий газар, Чиглэлийн ахлах
- 2025 оноос Эрчис Ойл ХХК, Хуульч

**Б.БАТ-ОТГОН****Боловсрол, мэргэжил:**

- 1991-1995 онд МУИС-Олон улс харилцааны сургууль, Олон улсын харилцаа, Бакалавр
- 2006-2008 онд АНУ, Жорж Тауны их сургууль, Төрийн удирдлага, Магистр
- 2015-2017 онд МУИС-Хууль зүйн сургууль, Эрх зүйч, Бакалавр

Ажлын туршлага:

- 1996-2001 онд ЭМНХЯ, Мэргэжилтэн
- 2001-2006 онд НҮБ СТГ, Төслийн зохицуулагч
- 2008-2012 онд НДЕГ, Газрын дарга
- 2012-2016 онд АТГ, Хэлтсийн дарга
- 2016-2023 онд ТЕГ, Хэлтсийн дарга
- 2024 оноос Кеучлаб ХХК, Гүйцэтгэх захирал

**Э.ЦОВОО****Боловсрол, мэргэжил:**

- 2004-2007 онд БНХАУ, Далианы их сургууль, Олон улсын эдийн засаг, худалдаа, Бакалавр
- 2008-2010 онд СЭЗИС, Бизнесийн удирдлагын магистр
- 2019 оноос ОХУ, Москвагийн Улсын удирдлагын их сургууль, Докторант

Ажлын туршлага:

- 2007-2008 онд ХААИС, ЭЗБС, Менежментийн тэнхим, Багш
- 2008 оноос СЭЗИС, Бизнесийн удирдлагын тэнхим, Ахлах багш

**Б.ЭНХМӨРӨН****Боловсрол, мэргэжил:**

- 1998-2003 онд ШУТИС ҮТДС, Технологич, инженер, Бакалавр
- 2015-2018 онд, СЭЗИС, Санхүүч, Бакалавр

Ажлын туршлага:

- 2004-2006 онд ШУТИС ҮТДС, Лаборант
- 2006-2007 онд Эй Си Эйч ХХК, Үйл ажиллагааны менежер
- 2008-2013 онд Альфа-Уан ХХК, Үйл ажиллагааны менежер
- 2013-2015 онд УБ-Элит ОУ-ын дунд сургууль, Нарийн бичиг
- 2015-2018 онд Альфа-Уан ХХК, Үйл ажиллагааны менежер
- 2018 оноос Альфа-Уан ХХК, Санхүү хариуцсан менежер



Ц.АЛТАНГЭРЭЛ

Боловсрол, мэргэжил:

- 2003-2007 онд Түшээ дээд сургууль, Эрх зүйч, Бакалавр
- 2012-2019 онд МУИС-Хууль зүйн сургууль, Хууль зүйн ухааны магистр

Ажлын туршлага:

- 2008-2013 онд Чингэлтэй дүүргийн ЗДТГ, 5-р хороо, Засаг дарга
- 2013-2014 онд Монголын Авто замчдын холбоо ТББ, Мэргэжилтэн
- 2015-2017 онд Сайн хүнс трейд ХХК, Менежер
- 2017-2021 онд Хан-Уул дүүргийн ЗДТГ, 16-р хороо, Засаг дарга
- 2021-2023 онд Хан-Уул дүүрэг, ТНАА хэлтэс, Дарга
- 2023-2024 онд Хан-Уул дүүрэг, 25-р хороо, Засаг дарга
- 2024-2025 онд Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ, Дарга
- 2026 оноос Зорчигч тээвэр-4 ОНӨААТҮГ, Бүтээмж хариуцсан менежер.



Д.ГАЛХҮҮ

Боловсрол, мэргэжил:

- 1993-1997 онд МУИС-Эдийн засгийн сургууль, Нягтлан бодогч, эдийн засагч, Бакалавр
- 2003-2005 онд Япон улс, Кобе их сургуулийн Олон улсын хамтын ажиллагаа судлалын сургуулийн бүс нутгийн хамтын ажиллагааны бодлого судлал, Эдийн засгийн ухааны магистр

Ажлын туршлага:

- 1998-2003 онд Жагар Интернэшнл ХХК, Гэрэл-Интернэйшнл ХХК, Нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогч
- 2006-2007 онд НҮБ хөгжлийн хөтөлбөр /Даян дэлхийн байгаль хамгаалах сан, Байгаль орчны яам/ Их Говь төслийн нэгж, Захиргаа, санхүү хариуцсан мэргэжилтэн
- 2006-2009 онд Актив аудит ХХК, Туслах аудитор
- 2007 онд Байгаль орчин аялал жуулчлалын яам, Дэлхийн банк /Монголын нүүрстөрөгчийн санхүүжилт/ Байгаль орчны шинэчлэлийн төслийн нэгж, Санхүүгийн менежер бөгөөд мониторингийн хянагч
- 2011-2012 онд Дэлхийн банк, Тогтвортой амьжиргаа төслийн II шат /Бичил санхүүгийн нэгж, Дотоод аудитор
- 2011-2012 онд Дэлхийн банк, Сангийн яам, Монголбанкны хяналт шалгалтын газар, Техникийн дотоод зөвлөх
- 2012-2022 онд Прайсвотерхаус Куперс Аудит ХХК, Зах зээлийн удирдагч, аудитор, менежер
- 2018-2024 онд, Олон улсын Дотоод аудитуудын Институтын Монгол улс дахь МҮДАХолбоо, ТУЗ-ийн гишүүн
- 2021-2024 онд, ЛэндМН ББСБ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 2024-2025 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Төслийн удирдлагын албаны ахлах менежер
- 2024 оноос Анд энерги ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 2025 оноос Сэлбэ 20 минутын хот корпораци ХХК, Дотоод аудитын хэлтсийн дарга

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

“Төрийн банк” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, “Төрийн банк” ХК-ийн 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дараах нэр дэвшигчдийг “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнээр 2028 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл 2 (хоёр) жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:

- 1.1.;
- 1.2.;
- 1.3.;
- 1.4.;
- 1.5.;
- 1.6.;
- 1.7.;

2. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүний цалинг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 (хоёр) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосугай.

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль тогтоомж, “Төрийн банк” ХК-ийн дүрэм, “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.ХУЛАН

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №2

Компанийн оноосон нэр: “ТӨРИЙН БАНК” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: ЭНГИЙН

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 09 цагт хосолсон /танхим, зайнаас/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
2	“Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай			

2026 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

САНАМЖ

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас www.statebank.mn/-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичин өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан: _____

--ооо--

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №3

Компанийн оноосон нэр: “ТӨРИЙН БАНК” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: ЭНГИЙН

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 09 цагт хосолсон /танхим, зайнаас/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал			
3	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай			
	Нэр дэвшигчид	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ц.Булганхишиг			
2	Т.Ариунбаатар			
3	Г.Саруул			
4	С.Болдбаяр			
5	Б.Бат-Отгон			
6	Э.Цовоо			
7	Б.Энхмөрөн			
8	Д.Галхүү			
9	Ц.Алтангэрэл			

2026 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

САНАМЖ

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас /www.statebank.mn/-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичин өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан: _____

